ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ
13335 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Нам Ян Жугийн гудамж 32/1, Утас: 45 39 94,
Факс: (976-11) 45 86 99, E-mail: info@nccd.gov.mn,
http://www.nccd.gov.mn

2024.08.27 № 3-2/1009.

танай _____________-ны № _____________-т

ДУУ, ДҮРС БИЧЛЭГ БОЛОН
ПРОГРАММ ХАНГАМЖ, ВЭБ
ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ АЖ
АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДАД

Хамтран ажиллах тухай

Тус төвөөс зохион байгуулах гэж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан “Эхээс хүүхдэд ХДХВ, тэмбүү болон гепатитийн В вирусийн халдвар дамжихыг зогсоох арга хэмжээ” онлайн интерактив сургалтын программ хөгжүүлэх ажил хийх шаардлагатай байгаа тул “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 зүйлд заасны дагуу үнийн саналыг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор tender@nccd.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт 2 хуудастай

ДЭД ЗАХИРАЛ А.ШИНЭХҮҮ-Г

Халдварт өвчин судлалын үндэсний<br>төвийн 2024 оны 3-2/1009 дугаартай<br>албан бичгийн хавсралт

**Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан “Эхээс хүүхдэд ХДХВ, тэмбүү болон гепатитийн В вирусийн халдвар дамжихыг зогсоох арга хэмжээ” онлайн интерактив сургалтын программ хөгжүүлэх ажлын даалгавар**

| № | Үйл ажиллагаа | Тавигдах шаардлага |
|---|---|---|
| 1 | Онлайн сургалтын вэб сайт хөгжүүлэх | - Сургалтын программ нь хэдэн ч дэд бүлэгтэй, бүлэг нь дотроо дэд хичээлтэй байх боломжтой байх<br>- Хичээл нь PDF, видео болон аудио форматтай байх<br>- Сургалтуудыг ангилан харуулах, ангилалын дагуу сургалтууд оруулах боломжтой байх<br>- Суралцагч нэвтэрч орох бүртгэлийн хэсэгтэй байна.<br>- Суралцагч нэвтэрч орсоны дараа интерактив хичээлийг үзэх боломжтой байх<br>- Суралцагчийн болон админ гэсэн 2 дэд вэб сайттай байх<br>**Суралцагчийн хэсэг:**<br>- Нэвтрэх<br>- Профайл засах<br>- Сургалт авах<br>- Сургалт үзэх<br>- Сорил өгөх<br>- Сертификат авах<br>- Админ хэсэг рүү чатлах боломжтойгоор хийгдэх<br>**Админ хэсэг:**<br>- Сургалтуудын ангилал удирдах /хичээл нэмж оруулах, өөрчлөх/<br>- Сургалтын бүртгэл, тохиргоо удирдах, засах<br>- Цахим сургалтанд хамрагдсан тайлан мэдээ авах<br>- Суралцагчаас ирсэн чатыг удирдах<br>- Сорилын мэдээлэл дүн шинжилгээ хийх, хянах<br>**Үндсэн сургалтын программ нь дараах бүтэцтэй байна**<br>- Агуулга<br>- Танилцуулга хичээл<br>- Видео хичээл<br>- Сорил<br>- Модуль хичээл<br>- Мэдээлэл сургалт сурталчилгаа гэсэн бүтэцтэй байна.<br>**Бүтэцэд тавигдах шаардлага:**<br>➢ **Агуулга:** Агуулга хэсэгт хэдэн ч сэдэв оруулах болмжтой байх Материалыг хэвлэх, татаж авах, и-мэйл хаяг руу авах боломтой байх<br>➢ **Танилцуулга хичээл:** Ppt сургалтын материалыг сэдэв сэдвээр нь программчилж оруулах, хичээлийг автомат |

| | | |
|---|---|---|
| | | тоглуулагч өгөгдэлтэйгээр, хугацаа тохируулж ажиллуулж болохоор хийх<br>➢ **Видео хичээл:** Видео бичлэгэнд компьютер график, дизайн хийх, сайжруулах, видео хичээлийг татаж авах боломжгүйгээр тохируулга хийх<br>➢ **Мэдээлэл, сурталчилгаа:** Хичээлийн сэдэвтэй холбоотой бүх мэдээлэл, сурталчилгааны материал, видео, анимэйшнийг сургалтын программ руу байршуулах, суралцагч эдгээр материалыг татаж авах, и-мэйлээр илгээх, хэвлэх боломжтойгоор тохируулга хийх<br>➢ **Сорил:** Сургалт бүрийн хувьд хэдэн ч сорил агуулж болох, суралцагч анх нэвтэрч ороход заавал сорил бөглөх бөгөөд давтан нэвтрэхэд сорилыг дахин бөглөхгүйгээр интерактив хичээлийг бүрэн үзэж дууссаны дараа дахин бөглөх, сүүлд бөглөсөн сорилын оноогоор гэрчилгээ авах боломжтой байхаар программчлах бөгөөд сорилыг бөглөж дууссаны дараа автоматаар үнэлгээг суралцагч харах боломжтой байхаар хийх |
| 2 | Дүрс бичлэг хийх | - 1 сэдэв нь 10-30 минутын хугацаатай 8 дүрс бичлэг хийх<br>- Монтаж, эвлүүлэг дуу оруулалт хийх<br>- Видео бичлэгэнд компьютер график, дизайн хийх |
| 3 | Бусад шаардлагатай бичиг баримт | - Байгууллагын танилцуулга<br>- Ижил төстэй ажил гүйцэтгэж байсан туршлагын талаарх 2-оос доошгүй гэрээ<br>- Ажиллах хүчний танилцуулга |